

MNS 2305 :94

- г/ уулын малталтын төрөл, дугаар
- д/ дээж авсан гүн, м-ээр
- е/ хөрсний төрөл
- ж/ хөлдүү хөрс бол түүний температур
- з/ дээж авсан хүний нэр, албан тушаал гарын үсэг
- и/ дээж авсан он, сар, өдөр

4.7 Савласан дээжийг лабораторийн шинжилгээнд явуулахын тулд жижигэвтэр хэмжээний мод болон төмөр хайрцганд хийнэ.

Гэхдээ цулмаг дээж хийсэн хайрцагны хананы завсарт 3-4 см, дээж хооронд 2-3 см-ийн зузаантай модны үртэс, зоргодос / гэсгэлэн хөрсний дээжний чийгтэй, хөлдүү хөрсний дээжинд хуурай / хийж чигжинэ. Дээж бүхий хайрцаганд дээжний шинжилгээний захиалын хуудсыг хийж, гадна талд нь явуулагч болон хүлээн авагч байгуулагын хаяг, эвдэлж, гэмтэхээс болгоомжлуулсан анхааруулгыг бичсэн байна.

5 Дээжийг тээвэрлэх, хадгалах

5.1 Цулмаг дээж нь тээвэрлэлтийн үед температурын болон механик нөлөөлөлд орох ёсгүй.

5.2 Гэсгэлэн дээжийг дулаан нөхцөлд, хөлдүү дээжийг хасах температуртай нөхцөлд буюу хөргөгчид тээвэрлэнэ.

5.3 Энэ стандартын 4.6, 4.7-гийн шаардлагыг хангаагүй баримт бичигтэй дээжийг лабораторит хүлээн авах, хадгалах буюу шинжилгээ хийхийг хориглоно.

5.4 Байгалийн чийгийг нь тодорхойлох эвдэрсэн бүтэцтэй, цулмаг дээжийг хадгалахдаа дараах шаардлагыг хангана. Үүнд:

а/ гэсгэлэн дээжийг хадгалах өрөө тасалгааны агаарын температур 2-10°C , харьцангуй чийглэг 70-80% байна.

б/ хөлдүү цулмаг дээжийг хадгалах өрөө нь хасах температуртай харьцангуй чийглэг 80-90% байна.

в / дээж хадгалах өрөө нь динамик үйлчилгээнд орохгүй байх

г/ цулмаг дээжийг тавиур дээр нэг эгнээгээр хаягийг дээш нь харуулж хураах

д/ дээжийг бие биендээ шүргэхгүйгээр хураасан байна.

Эвдэрсэн бүтэцтэй дээжийг тавиур дор байрлуулна.

5.5 Энэ стандартын 5.4-ын шаардлагыг хангасан өрөө тасалгаанд хатуу, хагас хатуу консистенцтэй шаварлаг болон бага чийгтэй элсэн хөрсний дээжийг 3 сар, бусад хөрсний дээжийг 1.5 сар / дээж авсан өдрөөс шинжилгээнд орох хүртэл / хадгална.

5.6 Хэрэв 5,4 –ын шаардлага хангасан өрөө тасалгаа байхгүй тохиолдолд 15 хоногоос илүү хадгалж болохгүй.

5.7 Байгалийн чийг тодорхойлох эвдэрсэн бүтэцтэй дээжийг 2 хоног хадгална.

Тайлбар: Дээж авсаны дараа жигнэсэн дээжийг 2 хоногоос дээш хадгалж болохгүй

5.8 Тээвэрлэх, хадгалах горимыг зөрчиж гэмтээсэнд цулмаг дээжийг эвдэрсэн бүтэцтэй дээжинд тооцон зохих шинжилгээг хийнэ.


ТӨГСӨВ



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ХӨРС.
ДЭЭЖ АВАХ, САВЛАХ, ТЭЭВЭРЛЭХ,
ХАДГАЛАХ ЖУРАМ

MNS 2305 : 94



СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
УЛААНБААТАР
1994

1.Боловсруулсан:

**Барилгын инженер хайгуулын эрдэм
шинжилгээ үйлдвэрлэл үйлчилгээний
“ Их үүсгэл ” компани**

Зохиогчид: Д. Дашням / ахлах инженер /
С. Должин / ахлах инженер /

Батлуулахаар оруулсан: Дэд бүтцийн хөгжлийн яам

Ч. Зулзагабаатар / дэс түшмэл /

Үндэсний стандартчилал, хэмжилзүйн төв

О. Чилхаасүрэн / хэлтсийн дарга /
М. Батнасан / стандартчилагч инженер /

2. Стандартын үзүүлэлт, шаардлагын түвшин

Түвшинд хүрсэн буюу давсан бүлэг, зүйлийн дугаар	Олон улсын болон гадаад орны стандартын тэмдэглэгээ, бүлэг зүйл
Стандарт бүхэлдээ	ГОСТ 12071-84

3. Стандартад үзлэг хийх хугацааа
Анхны үзлэгийг 2000 онд, дараа нь таван жил тутамд

4. Иш татсан стандарт:

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Заавал мөрдөнө

Ангилалтын код 13.080.20

Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам Грунты. Отбор, упаковка, транспортирование и хранение	MNS 2305 :94
Soils. Sampling, packing, transportation and keeping of samples	УСТ 2305-76-гийн оронд

Үндэсний стандартчилал, хэмжилзүйн төвийн тэргүүлэгчдийн 1994 оны 26 дугаар тогтоолын дагуу 1995 оны 01 дүүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Энэ стандарт нь төрөл бүрийн барилга байгууламжийн буурь болох бүх төрлийн хөрснөөс дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах шаардлагыг тогтооно.

1. Ерөнхий зүйл

1.1 Хөрсний дээж нь хөрсний байгалийн бүтэц ширхэгийн бүрдлийг хадгалсан эвдэрсэн ба эвдрээгүй / цулмаг / бүтэцтэй байна.

1.2 Дээжийг уулын малталтын / цооног , цурф, барилгын суурийн нүх / цэвэрлэсэн ёроол болон хананаас авна.

1.3 Цулмаг дээжийн талыг тусгайлан тэмдэглэнэ.

1.4 Дээж авах уулын малталтын гадаргуугийн ус ба хур тунадаснаас хамгаалах шаардлагатай.

1.5 Хөлдүү хөрсний дээжийг агаарын хасах температуртай үед авах ба хэrvээ дулааны улиралд авсан бол дулаан тусгаарлагчийг яаралтай хийж, хасах температурт хадгална.

1.6 Хөлдүү хөрсний цулмаг дээж авах уулын малталтын гэсэлт болон ус норолтоос хамгаалсан байх хэрэгтэй.

1.7 Хөлдүү хөрсний механик шинж чанарыг тодорхойлох дээжийг тусгай журмын дагуу авна.

1.8 Лабораторын иж бүрэн ба тусгай судалгаа хийхэд дээжийн тоо, хэмжээ нь тохирсон байвал зохино. Тэгэхдээ эвдэрсэн бүтэцтэй дээж 2.5-3.0 кг, уулын малталтаас авсан цулмаг дээж нь 20x20x20 км байна.

2. Багаж, материал

2.1 Эвдэрсэн бүтэцтэй дээжийг хүрз, хутга ба өрөмдлөгийн хошууны тусламжтайгаар авна.

2.2 Цулмаг дээжийг хүрз, хутга, орлогч цагираг, дээж авагч зэргээр авна.

MNS 2305 :94

2.3 Дээж авагч нь цулмаг дээжийн байгалийн чийг алдагдсан хэсгийг огтлож хаяхад дээжийн хэмжээ нь туршилтын багажийн хэмжээнээс багагүй байх нөхцөлийг хангасан байна.

Энэ нөхцөлд дээжийн цулмаг эвдэрсэн хэсгийг дараахь байдлаар тооцно. Үүнд: хатуу холбоостой хөрсөнд 3 мм, том хэмхдэст хөрсөнд 20 мм, элсэн ба тоосорхог шаварлаг хөрсөнд урсалтын үзүүлэлт / J_c / нь 0.75-аас бага үед 10 мм, 0.75 –аас их үед 5 мм байна.

2.4 Эвдэрсэн бүтэцтэй дээжийг савлахад хөрсний жижиг хэсгийг хадгалж чадах нягт эдээр хийсэн уут мөн битүү таглаатай зэвэрдэггүй металл юмуу хуванцар сав хэрэглэнэ.

2.5 Цулмаг дээжийг савлахад зэвэрдэггүй материалаар бэлтгэсэн сав, хайрцаг, боодол / лааны тостой цаас, мароль гэх мэт /-ыг хэрэглэнэ.

2.6 Цулмаг дээжийг тусгаарлахад жингийн 35-50 %-д замын хар тос / битум / хийсэн лааны тос хэрэглэнэ.

3 Дээж авах

3.1 Эвдэрсэн бүтэцтэй дээж авах

3.1.1 Хадан хөрснөөс дээж авахдаа дэлбэлэх буюу өрмийн хошуугаар авна.

3.1.2 Өгөршилд орж ан цаваар хэсэгчигдсэн хадан хөрс, бүх төрлийн сэвсгэр хурдаснаас дээж авахдаа тусгай зориулалт бүхий хутга, хүрз, огтлогч цагираг, дээж авагч, өрөмдлөгийн хошуу зэргийг хэрэглэнэ.

3.1.3 Гэсгэлэн нөхцөлд усаар ханасан байдалд оршин буй хөрснөөс дээж авахдаа хөрсний байгалийн чийгийг хадгалах шаардлагатай тул өрөмдлөгийн ажилд угаалын шингэн хэрэглэж болно.

Угаалын шингэний нягт $1.2 \text{ г} / \text{см}^2$ –аас багагүй байна. Байгалийн чийгийг хэвээр нь хадгалах нөхцөлд угаалын шингэн хэрэглэж болохгүй. Хөлдүү хөрснөөс дээж авахдаа өрөмдөх алхмын урт / рейс / 0.3 эргэлтийн хурд 60 эр/мин-аас ихгүй байна. Өрөмдлөгт хасах температуртай болтол хөргөсөн агаар үлээлгэн хэрэглэж болно.

3.1.4 5 см-ээс ихгүй зузаантай үелсэн хадан бус сэвсгэр хөрснөөс ховилон аргаар дээж авч болно.

3.2 Цулмаг дээж авах

3.2.1 Хөрснөөс цулмаг дээжийг тодорхой хэлбэр дүрстэй / ихэвчлэн цилиндр, куб, параллелипед гэх мэт / -гээр хутга, хүрзээр хөрсний бүтцийг эвдэхгүй авах шаардлагатай.

3.2.2 Цулмаг дээж нь огтлогч цагирагаар авсан үед тодорхой хэлбэр дүрс хадгалах шаардлагагүй бөгөөд цагирагийн дотор талын диаметр нь 2.3-ын нөхцлийг хангасан байна. Дээжний өндөр нь диаметрээсээ илүүгүй байна.

3.2.3 Ан цав бүхий хадан хөрс том хэмхдэст хөрснөөс цулмаг дээж авахдаа савыг дарж шигтгэх аргаар авч болно.

3.2.4 Цооногоос цулмаг авахдаа дээж авагчийг хэрэглэнэ. Тэгэхдээ өрөмдөх алхмын урт нь хадан хөрсөнд 2 Ом, том хэмхдэст хөрсөнд 1.5 м, элсэн ба шаварлаг хөрсөнд 0.7 м байна.

3.2.5 Угаалгын шингэнд болон өрөмдөх, механик үйлчилгээнд эвдрэхгүй хадан хөрснөөс дээж авахдаа ердийн яндан, бусад тохиолдолд давхар яндан хэрэглэнэ. Угаалгын шингэнд шавар болон ус хэрэглэж болно.

